



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай  
орчныг хангахад чиглэсэн зарим  
арга хэмжээний тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хэрэгжиж буй стандартыг мөрдүүлэх зорилтын хүрээнд орчны тохижилт, инженерийн шугам сүлжээ, авто замын засвар үйлчилгээний нөхцөл байдал, нэгдсэн үзлэг судалгаа хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж сайжруулах талаар ДААЛГАХ нь:

1. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай.

1.1. Барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэх, засварын ажил хийх үед мөрдөх орчны аюулгүй байдлыг хангах, барилгын талбайн түр хашааны MNS 5414:2004 болон холбогдох бусад стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан үр дүнг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хот байгуулалт, хөгжлийн газар /Б.Ууганбаяр/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар /С.Төмөрдулам/-т;

1.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгажилтын ажлын явц, тэдгээрийн талаар авах арга хэмжээний саналыг боловсруулж 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хот байгуулалт, хөгжлийн газар /Б.Ууганбаяр/-т;

1.3. Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэх, үерийн усны далан сувгийг зориулалтын бусаар өөрчилсөн зөрчлийг арилгах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Дүүргүүдийн засаг дарга нар, "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ /Г.Цэрэнноров/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т;

1.4. Үерийн усны хамгаалалтын зурваст орсон айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэх, хамгаалалтын зурвасыг чөлөөлөх, түүнтэй холбогдсон зардлын төсөв, тооцоог гарган 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/-т;

1.5. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийг стандартын дагуу хашаажуулах ажлыг гүйцэтгэх, шаардлагатай төсвийг гаргах, кадастрын мэдээллийн санд оруулах, гэрчилгээжүүлэх, газрын төлбөрөөс чөлөөлүүлэх талаар эрх зүйн орчинг судалж танилцуулахыг "Ус сувгийн Удирдах газар" ОНӨААТҮГ /Ц.Төрхүү/ -т; ✓

1.6. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын хамгаалалтын бүсэд суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эзэмших эрхийн гэрчилгээг цуцлах арга хэмжээний саналыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн

дотор гаргаж танилцуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/, "Ус сувгийн Удирдах газар" ОНӨААТҮГ /Ц.Төрхүү/-т;

1.7.Түгээмэл тархацтай ашигт малтмалын уурхайн бүсийн тэмдэг, тэмдэглэгээ, хашааг холбогдох хууль, стандарт, норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгүүлэх, хуульд заагдсан хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлүүдийг цуцлах арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/-нд;

1.8.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй аж ахуйн нэгжүүдэд ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах, эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийг ажлыг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т;

1.9.Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, авто замын тэмдэг, тэмдэглэгээ, гарц, гэрэл дохио, хурд сааруулагч, анхааруулга санамж бүхий тэмдэг байрлуулах, шаардлагатай газруудад хайс, хашлага байрлуулах, орчны тохижилтын стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж үр дүнг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/, Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн Замын цагдаагийн газар /Д.Дашдорж/-т;

1.10.Эмнэлэг, эмнэлгийн байгууллагуудын орчны тохижилт, иргэдийн аюулгүй, саадгүй үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлэг орчмын явган хүний зам, авто машины орц гарц, зогсоолын хүрэлцээг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллан үр дүнг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т;

1.11.Орон сууц хороолол, гэр хороолол, зуслангийн бусад авто замын орц, гарц гаргах ажлыг зохион байгуулах, яаралтай тусламжийн үеийн авто тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх бололцоогоор хангаж ажиллахыг Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн Замын цагдаагийн газар /Д.Дашдорж/, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/-нд;

1.12.Төвийн болон орон сууцны хорооллын дундах авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаагүйгээс иргэдийн аюулгүй зорчиход саад учруулж буй эвдрэл, гэмтлийг засварлах, найдвартай удаан эдэлгээний шаардлагыг хангасан авто зам барих, засварлах ажилд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/-т;

1.13.Явган хүний зам, замын зорчих хэсэгт саад учруулж буй зүйлс барилгын өргөтгөл, хайс хашлага, сурталчилгаа, мэдээллийн самбар, шат, довжоо гэрлийн шон зэргийг Дүүрэг, хороо, гудамж, талбай тус бүрээр, тоо ширхэг, хэмжээ, байршил тус бүрээр ангилан гаргаж чөлөөлөх ажлыг зохион байгуулж үр дүнг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/, Хот байгуулалт, хөгжлийн газар /Б.Ууганбаяр/-т;

1.14.Нийслэлийн хэмжээнд хийгдэж буй бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг холбогдох стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт хугацаанд нь хийж гүйцэтгүүлэх, чанар, өнгө үзэмжид онцгой анхаарах, үзлэг, судалгааны дүнгээр гарсан орчны бохирдол, тоосжилт ихээр үүсгэж буй сул шороон хөрстэй талбайд тохижилт, ногоон байгууламжийн ажил төлөвлөж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагууд, дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, холбогдох бусад байгууллагуудад тус тус;

1.15.Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн шон, цахилгаан хангамжийн агаарын шугамын тулгуур шонгуудаас унжсан цахилгааны болон кабел утаснуудыг цэгцлэх, инженерийн шугам сүлжээний худгийн тагны бүрэн байдал, худгийн түвшин, ашиглалт хамгаалалтыг сайжруулах болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх ажлыг Дүүргүүдийн Засаг дарга нарт;

1.16.Автобусны буудлын тохижилт, өнгө үзэмжтэй байдал, чиглэлийн мэдээлэл бүхий самбар байрлуулах, иргэдийн ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг хангуулж ажиллахыг Нийтийн Тээврийн үйлчилгээний газар /Ч.Сайханбаяр/-т;

1.17.Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамгаалалтын зурваст олгогдсон болон зөвшөөрөлгүй буусан иргэн, аж ахуйн нэгжийн газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулах, холбогдох зардлын тооцоог гарган санал боловсруулж үр дүнг 2019 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/-нд.

2.Албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг "Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар"-т 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг дээрх байгууллагуудад.

3.Албан даалгаврын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, биелэлтэд нь хяналт тавьж, ажлын гүйцэтгэл үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Отгонсүхэд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН